ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэрлэн сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: ДОА-2021/67/СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn
Чойбалсан хот
2021 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд
Тэргүүлэх аудитор: Б.Болортуул
Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn
Хэлтсийн дарга бөгөөд аудитын
менежер: И.Сэмжидмаа
Утас: 70584204 Цахим хаяг: Semjidmaai@audit.gov.mn
Гэрээт аудитор: З.Шинэхүү
Утас: 70584204 Цахим хаяг:Shinekhuuz@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| ДОА | Дорнод аймаг |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |

## Агуулга


1.Хараат бус аудиторын дүгнэлт....3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан....5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан....5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан....6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан....8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан....9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан....9
3. Аудитын тайлан....10
3.1. Ерөнхий зүйл....10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй....10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт....10
3.4. Материаллаг байдал....11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд....11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт....12
3.7. Шилэн дансны мэдээлэл....12
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт....13
3.9. Аудитын илрүүлэлт....13
Залруулсан алдаа....13
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил....13
Аудитын зөвлөмж....13
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд....13
4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт....14

# 1.Хараат бус аудиторын дүгнэлт

ХЭРЛЭН СУМЫН 14 ДҮГЭЭР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Х.НАРАНТУЯА ТАНАА

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000. Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2021.02.24 № 227

танай ______ -ны № ______ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэрлэн сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэрлэн сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Хэрлэн сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнээгүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

011021295

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **96,148,005.34** | **130,141,147.60** |
| **33** | **АВЛАГА** | 00.00 | 1,677,054.51 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 00.00 | 1,677,054.51 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 96,148,005.34 | 128,464,093.09 |
| **354** | **Хангамжийн материал** | 96,148,005.34 | 128,464,093.09 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 00.00 | 116,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 96,148,005.34 | 128,348,093.09 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,198,442,480.48** | **2,196,969,611.33** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 2,198,442,480.48 | 2,196,969,611.33 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,947,284,480.48 | 1,945,954,611.33 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,907,227,717.84 | 1,960,775,761.84 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -40,411,569.48 | -81,646,824.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 57,399,811.50 | 61,924,161.50 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -47,974,658.83 | -49,939,561.52 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 68,885,011.50 | 50,235,106.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -37,339,283.24 | -30,885,826.56 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 66,833,801.00 | 66,833,801.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -27,336,349.81 | -31,342,006.93 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 251,158,000.00 | 251,015,000.00 |
| 39301 | Програм хангамж | 946,000.00 | 1,111,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -638,000.00 | -946,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 250,850,000.00 | 250,850,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,294,590,485.82** | **2,327,110,758.93** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **00.00** | **1,677,054.51** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 00.00 | 1,677,054.51 |
| **413** | **Өглөг** | 00.00 | 1,677,054.51 |
| **4136** | **Бусад өглөг** | 00.00 | 1,677,054.51 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 00.00 | 1,677,054.51 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,294,590,485.82** | **2,325,433,704.42** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 2,294,590,485.82 | 2,325,433,704.42 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 600,973,993.50 | 600,973,993.50 |
| 51101 | Өмч: - төрийн | 350,123,993.50 | 350,123,993.50 |
| 51103 | - хувьцаат | 250,850,000.00 | 250,850,000.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -21,561,267.09 | 9,281,951.51 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -21,561,267.09 | -21,561,267.09 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 30,843,218.60 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,715,177,759.41 | 1,715,177,759.41 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,294,590,485.82** | **2,327,110,758.93** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **582,075,362.00** | **634,194,225.75** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **59,332,162.00** | **88,418,625.75** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 8,896,240.00 | 24,349,732.75 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 8,896,240.00 | 24,349,732.75 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 8,896,240.00 | 24,349,732.75 |
| **121** | **Хөрөнгийн орлого** | 50,435,922.00 | 64,068,893.00 |
| 121001 | Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого | 50,435,922.00 | 64,068,893.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **35,916,500.00** | **26,094,100.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 486,826,700.00 | 519,681,500.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 198,000.00 | 1,640,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 1,640,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 198,000.00 | 00.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 00.00 | 24,454,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 00.00 | 24,454,100.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 35,718,500.00 | 00.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 35,718,500.00 | 00.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **583,073,711.93** | **599,799,452.99** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **583,073,711.93** | **599,799,452.99** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 581,349,732.37 | 579,137,973.35 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 341,086,846.14 | 405,010,700.00 |
| 210101 | Үндсэн цалин | 300,022,266.14 | 306,664,852.71 |
| 210102 | Нэмэгдэл | 16,277,163.00 | 70,172,881.29 |
| 210104 | Урамшуулал | 24,787,417.00 | 28,172,966.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 46,349,798.00 | 50,549,385.36 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 32,573,898.00 | 34,380,727.36 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,444,000.00 | 4,042,048.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,755,200.00 | 3,233,783.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 688,800.00 | 808,530.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,887,900.00 | 8,084,297.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 32,906,046.30 | 21,671,378.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,880,206.00 | 4,843,538.00 |
| 210302 | Түлш, халаалт | 17,409,004.00 | 11,701,379.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 8,616,836.30 | 5,126,461.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 6,934,127.80 | 3,356,889.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 432,800.00 | 496,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 00.00 | 500,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 469,543.00 | 355,800.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 550,050.00 | 510,800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 865,657.00 | 345,600.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 4,616,077.80 | 1,148,189.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 93,429,030.00 | 37,771,275.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 100,000.00 | 161,600.00 |
| 210502 | Хоол, хүнс | 93,136,530.00 | 37,609,675.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 192,500.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 920,000.00 | 43,360.00 |
| 210604 | Урсгал засвар | 920,000.00 | 43,360.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 212,000.00 | 48,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 212,000.00 | 48,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 715,000.00 | 43,400.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 535,000.00 | 43,400.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 180,000.00 | 00.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 58,796,884.13 | 60,643,585.99 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 500,000.00 | 500,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 357,000.00 | 598,782.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 57,939,884.13 | 59,544,803.99 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,723,979.56 | 20,661,479.64 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 300,000.00 | 100,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 300,000.00 | 100,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 1,423,979.56 | 20,561,479.64 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,423,979.56 | 20,561,479.64 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-998,349.93** | **34,394,772.76** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 00.00 | 3,551,554.16 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 00.00 | 3,551,554.16 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 00.00 | -3,551,554.16 |
| 5 | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-998,349.93** | **30,843,218.60** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **522,743,200.00** | **545,775,600.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **522,743,200.00** | **545,775,600.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 486,826,700.00 | 519,681,500.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 198,000.00 | 1,640,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 1,640,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 198,000.00 | 00.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 35,718,500.00 | 24,454,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 00.00 | 24,454,100.00 |
| 132002 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт | 00.00 | 00.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 35,718,500.00 | 00.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **522,743,200.00** | **545,775,600.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **522,743,200.00** | **545,775,600.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **521,019,220.44** | **525,114,120.36** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 344,386,844.14 | 405,010,700.00 |
| 210101 | Үндсэн цалин | 303,322,264.14 | 306,664,852.71 |
| 210102 | Нэмэгдэл | 16,277,163.00 | 70,172,881.29 |
| 210104 | Урамшуулал | 24,787,417.00 | 28,172,966.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 43,049,800.00 | 50,549,385.36 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 29,273,900.00 | 34,380,727.36 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,444,000.00 | 4,042,048.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,755,200.00 | 3,233,783.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 688,800.00 | 808,530.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,887,900.00 | 8,084,297.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 32,906,046.30 | 21,671,378.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,880,206.00 | 4,843,538.00 |
| 210302 | Түлш, халаалт | 17,409,004.00 | 11,701,379.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 8,616,836.30 | 5,126,461.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 2,948,000.00 | 3,656,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 432,800.00 | 458,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 00.00 | 500,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 469,543.00 | 351,300.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 219,000.00 | 281,100.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 550,050.00 | 510,800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,276,607.00 | 1,554,200.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 94,236,530.00 | 39,730,275.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 100,000.00 | 161,600.00 |
| 210502 | Хоол, хүнс | 93,136,530.00 | 37,609,675.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,000,000.00 | 1,959,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,400,000.00 | 700,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,400,000.00 | 700,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 212,000.00 | 48,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 212,000.00 | 48,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 880,000.00 | 208,400.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 700,000.00 | 208,400.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 180,000.00 | 00.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,000,000.00 | 3,539,982.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 500,000.00 | 500,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 500,000.00 | 3,039,982.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,723,979.56** | **20,661,479.64** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 300,000.00 | 100,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 300,000.00 | 100,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 1,423,979.56 | 20,561,479.64 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,423,979.56 | 20,561,479.64 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **00.00** | **00.00** | **00.00** | **00.00** | 00.00 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C08 | **2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **600,973,993.50** | **1,715,177,759.41** | **-21,561,267.09** | **00.00** | 2,294,590,485.82 |
| D01 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **600,973,993.50** | **1,715,177,759.41** | **-21,561,267.09** | **00.00** | 2,294,590,485.82 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **600,973,993.50** | **1,715,177,759.41** | **-21,561,267.09** | **00.00** | 2,294,590,485.82 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 30,843,218.60 | 00.00 | 30,843,218.60 |
| D09 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **600,973,993.50** | **1,715,177,759.41** | **9,281,951.51** | **00.00** | 2,325,433,704.42 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 522,545,200.00 | 521,121,220.44 | 546,384,700.00 | 523,574,120.36 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 522,545,200.00 | 521,121,220.44 | 546,384,700.00 | 523,574,120.36 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 522,545,200.00 | 521,121,220.44 | 546,173,800.00 | 523,474,120.36 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 344,397,300.00 | 344,386,844.14 | 405,010,700.00 | 405,010,700.00 |
| 210101 | Үндсэн цалин | 305,675,600.00 | 303,322,264.14 | 305,067,400.00 | 306,664,852.71 |
| 210102 | Нэмэгдэл | 14,480,700.00 | 16,277,163.00 | 69,857,700.00 | 70,172,881.29 |
| 210104 | Урамшуулал | 24,241,000.00 | 24,787,417.00 | 30,085,600.00 | 28,172,966.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 43,049,800.00 | 43,049,800.00 | 50,626,400.00 | 50,549,385.36 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 29,273,900.00 | 29,273,900.00 | 34,425,900.00 | 34,380,727.36 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,444,000.00 | 3,444,000.00 | 4,050,000.00 | 4,042,048.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,755,200.00 | 2,755,200.00 | 3,240,100.00 | 3,233,783.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 688,800.00 | 688,800.00 | 810,100.00 | 808,530.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,887,900.00 | 6,887,900.00 | 8,100,300.00 | 8,084,297.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 34,318,500.00 | 32,906,046.30 | 18,661,700.00 | 21,671,378.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,218,500.00 | 6,880,206.00 | 5,499,100.00 | 4,843,538.00 |
| 210302 | Түлш, халаалт | 18,200,000.00 | 17,409,004.00 | 12,753,200.00 | 11,701,379.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 8,900,000.00 | 8,616,836.30 | 409,400.00 | 5,126,461.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 2,750,000.00 | 2,750,000.00 | 3,663,200.00 | 3,656,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 250,000.00 | 234,800.00 | 465,800.00 | 458,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 200,000.00 | 00.00 | 500,000.00 | 500,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 600,000.00 | 469,543.00 | 351,300.00 | 351,300.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 200,000.00 | 219,000.00 | 281,100.00 | 281,100.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 500,000.00 | 550,050.00 | 510,800.00 | 510,800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,000,000.00 | 1,276,607.00 | 1,554,200.00 | 1,554,200.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 94,237,600.00 | 94,236,530.00 | 64,280,500.00 | 39,730,275.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 100,000.00 | 100,000.00 | 461,600.00 | 161,600.00 |
| 210502 | Хоол, хүнс | 93,137,600.00 | 93,136,530.00 | 61,851,100.00 | 37,609,675.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,000,000.00 | 1,000,000.00 | 1,967,800.00 | 1,959,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,400,000.00 | 1,400,000.00 | 1,070,000.00 | 700,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,400,000.00 | 1,400,000.00 | 1,070,000.00 | 700,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 212,000.00 | 212,000.00 | 48,000.00 | 48,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 212,000.00 | 212,000.00 | 48,000.00 | 48,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 880,000.00 | 880,000.00 | 767,100.00 | 208,400.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 700,000.00 | 700,000.00 | 767,100.00 | 208,400.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 180,000.00 | 180,000.00 | 00.00 | 00.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1000000.00 | 1000000.00 | 2046200.00 | 1899982.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 500,000.00 | 500,000.00 | 500,000.00 | 500,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 500,000.00 | 500,000.00 | 1,546,200.00 | 1,399,982.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 300000.00 | 300000.00 | 210900.00 | 100000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 300,000.00 | 300,000.00 | 210,900.00 | 100,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 300,000.00 | 300,000.00 | 210,900.00 | 100,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 522,545,200.00 | 522,545,200.00 | 551,107,100.00 | 544,135,600.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 522,545,200.00 | 521,121,220.44 | 546,384,700.00 | 523,574,120.36 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 522,545,200.00 | 521,121,220.44 | 546,384,700.00 | 523,574,120.36 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 39.00 | 39.00 | 39.00 | 39.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | 01.00 | 01.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 24.00 | 24.00 | 24.00 | 24.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 14.00 | 14.00 | 14.00 | 14.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл | |
|---|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **1,815,000.00** | |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **1,815,000.00** | |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | 1,815,000.00 | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | 175,000.00 | |
| 210401 | Бичиг хэрэг | | 125,000.00 | |
| 210404 | Ном, хэвлэл | | 50,000.00 | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 0.00 | 1640000.00 | |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 1,640,000.00 | |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 0.00 | 1815000.00 | |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | 1,815,000.00 | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 1,640,000.00 | |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 175,000.00 | |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | | |

## 3.Аудитын тайлан

### 3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Хэрлэн сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг эрхлэгч Х.Нарантуяа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 29-ноос 2021 оны 02 дугаар сарын 23–ны хооронд Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт аудитор З.Шинэхүү хариуцаж хэрэгжүүлэв.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Хэрлэн сумын 14 дүгээр цэцэрлэгийн захиргааны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

“ Сайн харилцаа, сайхан орчин, сонирхолтой тоглоом-ногоон хөгжил”

**Сайн харилцаа**-амжилтын үндэс. Иймд хүүхэд нэг бүрд хүн бүр халамж анхаарал тавьж, харилцааны эерэг чанарыг эрхэмлэн ажиллана.
**Сайхан орчин**-хөгжлийн түлхүүр. Хүн бүр хүүхэд бүрийн танин мэдэх хэрэгцээ сонирхолд нийцсэн эко ногоон орчин бүрдүүлж ажиллахыг эрхэмлэнэ.
**Сонирхолтой тоглоом**-тоглоом нь хүүхдийн суралцах үндсэн үйл. Хүүхэд тоглонгоо мэдлэг бүтээж суралцах, оюун, сэтгэхүй хөгжүүлэх үйлийг эрхэмлэнэ. Анги бүр сэдэвт, хөдөлгөөнтэй тоглоомын орчин бүрдүүлж ажиллахыг эрхэмлэнэ.
**Ногоон хөгжил-бидний ирээдүй**. Хүүхэд бүр цэцэг ургамал тарьж, үрсэлгээ хийж, сурч хөгжих, хөдөлмөрт суралцах, бүтээлч үйлээрээ хөгжин , насан туршийн боловсролын суурь чадвар эзэмшихэд дэмжлэг үзүүлж ажиллана.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

### 3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ

Хэрлэн сумын 14 дүгээр цэцэрлэгийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хэрлэн сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2020 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Хэрлэн сумын 14 дүгээр цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд "дунд" гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 болон 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг "дунд" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг өмнөх жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 583,073.7 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 11,661.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд тайлант оны үр дүнгийн тайлангийн зардлын 599,799.4 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 11,995.9 мянган төгрөг болгон материаллаг байдлыг өөрчлөв.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хэрлэн сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 32,520.3 мянган төгрөгөөр буюу 1.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | | |
| Авлага | | 1,677.1 | 1,677.1 |
| Урьдчилгаа | | | |
| Бараа материал | 96,148.0 | 128,464.1 | 32,316.1 |
| Үндсэн хөрөнгө | 2,198,442.4 | 2,196,969.6 | (1,472.8) |
| **Нийт хөрөнгө** | **2,294,590.5** | **2,327,110.8** | **35,520.3** |
| Өр төлбөр | | 1,677.1 | 1,677.1 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 2,294,590.5 | 2,325,433.7 | 30,843.2 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **2,294,590.5** | **2,327,110.8** | **35,520.3** |

Авлага дансны үлдэгдэл 1,677.1 мянган төгрөг болж 1,677.1 мянган төгрөгөөр өссөн нь хөгжлийн бэрхшээлтэй ажилтнаас ХХОАТ суутган тооцсоноос шалтгаалжээ.

Өглөгийн дансны үлдэгдэл 1,667.1 байгаа нь 2 ажилтны цалингаас ХХОАТ суутган тооцсоноос шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 128,464.1 мянган төгрөг болж 32,316.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант жилийн бараа материалын худалдан авалт 45,561.9 мянга, хандив тусламжаар 5,040.8 мянга, шилжүүлгээр 21,919.3 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, тайлант онд зарцуулалт 39,057.8 мянга, 1,148.2 мянган төгрөгийн бараа материалыг акталж устгаснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,196,969.6 мянган төгрөг болж 1,472.8 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгийн худалдан авалтаар 165.0 мянга, хөрөнгө оруулалтаар 53,548.0 мянга, хандиваар 7,910.4 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, үндсэн хөрөнгийн данснаас өмч хамгаалах зөвлөлийн шийдвэрийн дагуу 21,919.3 мянган төгрөгийн

үндсэн хөрөнгийг бараа материалын дансанд шилжүүлсэн, тайлант оны элэгдлийн зардал 41,176.9 мянган төгрөг байснаас шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,325,433.7 мянган төгрөг болж 30,843.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Хэрлэн сумын 14 дүгээр цэцэрлэгийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 52,118.8 мянган төгрөгөөр буюу 8.9 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 16,725.7 мянган төгрөгөөр буюу 2.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь цалин хөлс 4.4 хувь, бараа, ажил үйлчилгээний зардал 8.6 хувиар тус тус нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

## 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 756,272.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 756,272.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 209,887.6 мянган төгрөгөөр бууруулж 546,384.7 мянган төгрөгөөр баталсан байна.

### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 1 хэмжээг санхүүжүүлэхээр 546,384.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 546,384.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 525,389.1 мянган төгрөг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл нь 525,389.1 мянган төгрөг буюу 96.2 хувьтай байгаа нь урамшуулал 1,912.6 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардал 77.0 мянган төгрөг, норматив зардлаас 24,550.2 мянган төгрөг, эд хогшил худалдан авах зардлыг 370.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр 558.7 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

## 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд мэдээлбэл зохих 146 мэдээллээс 146 мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлж ирүүлсэн байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар “итгэл” үзүүлж, зөвлөмж өгөгдөөгүй болно.

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,677.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1 албан шаардлага хүргүүллээ.

Аудитаар нийт 1,677.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1,677.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,677.1 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага өглөө.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг тус тус зөрчин хөгжлийн бэрхшээлтэй 2 ажилтны цалингийн орлогоос нийт 1.677.1 төгрөгийн татвар суутгасныг санхүүгийн тайланд авлаг, өглөг үүсгэж залруулав.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар нийт 1,677.1 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа зөрчилд 1 албан шаардлага хүргүүллээ.

1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний цалингаас ХХОАТ-ыг суутгасан мөнгөнд авлага, өглөг үүсгээгүй нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22.1-т “Дараах орлогыг албан татвараас чөлөөлнө” 22.1.2-т “хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлого” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүллээ.

#### Аудитын зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөөгүй болно.

### 3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: **2020**

Аудитын нэр: ***Хэрлэн сумын 14 дүгээр цэцэрлэглийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит***

Аудитын код: ДОА-2021/67/СТА-ТШЗ

Шалгагдсан байгууллагын нэр: ***Хэрлэн сумын 14 дүгээр цэцэрлэг***

Мянган төгрөгөөр

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 2 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэний цалинаас ХХОАТ-ыг суутгасан мөнгөнд авлага, өглөг үүсгээгүй байна. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22.1.Дараах орлогыг албан татвараас чөлөөлнө 22.1.2-т ”хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлого” гэсэн заалуудыг зөрчсөн байна. | 1,677.1 | Албан шаардлага | Дарга | Х.Нарантуяа |
| **ДҮН** | | **1,677.1** | | | |